

Монгол домог зүйн өргөмжит нэр: Эрхий мэргэн ба Добу мэргэн

Хулуд Жамьянгийн Отгонбаяр 

Монгол Улсын Боловсролын Их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн ухааны
тэнхимийн багш, магистр, Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2025-03-31

Засварласан - Revised:
2025-05-19

Хэвлэгдсэн - Published:
2025-06-10

otgonbayar@msuc.edu.mn

ORCID: [0009-0006-4816-0216](https://orcid.org/0009-0006-4816-0216)



© 2025, Author(s)

Хураангуй: Энэхүү өгүүлэлдээ Монголын нууц товчооны хүүрнэл ба монголчуудын домог зүйн сэтгэлгээний дотоод суртал холбоог нэгэн миф домгийн өгүүлэмжээр тодруулах гэсэн юм. Ингэхдээ өвөг монголчуудын аж ахуйн соёлыг онцолж, Чингис хааны удам дээдсийн цуваан дахь зарим нэр нь оноосон нэр бус, харин домог зүйн утгатай хэмээн үзлээ. Өвөг монголчууд мал аж ахуй, ан гөрөөг хослон эрхэлж ирсэн билээ. Чингисийн Алтан ургийнхан анчин гөрөөчин удамтай. Тэдний байгуулсан Их Төр нь цэрэг дайны гүрэн байв.

Түлхүүр үгс: Домог зүйн сэтгэлгээ, миф домог, суртал номлол, өргөмжит нэр, Тэнгэр үзэл.

ОРШИЛ

Монголын нууц товчоон бол Чингис хаан тэргүүтэй Алтан ургийнхны байгуулсан Төрийн гэрээслэл-бодлогын номлол хэмээн би үздэг. Өөрөөр хэлбэл, тэдний улс төрийн үзэл суртал нь монголчуудын домог зүйн сэтгэлгээнд суурилсан Тэнгэрч үзэл, тэдний бодлого зорилго нь Монголын Энх Төрийг байгуулж дэлхий даяар амар амгаланг (Pax Mongolica) тогтоох явдал, тэр бодлогын гүйцэтгэл тайлан нь Монголын нууц товчоон ажгуу. Энэ хөлгөн сударт Чингис хааны өвөг дээдэс удам ургийг Дээр Тэнгэрээс гаралтай хэмээн товчоолсон нь домог зүйн утга юм.

Монголчуудын домог үлгэр буюу миф домгийн тогтолцоонд “Эрхий мэргэн” хэмээх нэгэн сонин содон домог байдаг. Билиг зүйчид энэ домог үлгэрийг домог зүйн ангиллын тэргүүн хэсэгт байршуулан авч үздэг. Сайхи миф нь домгийн цагийн суртал номлол агаад “бодлогын” агуулгатай хэмээн үзэж байгаа юм.

Үр дүн, хэлэлцүүлэг.

“Эрхий мэргэн” домгийн агуулгыг ерөнхийд нь хоёр хэсэгт хувааж авч үзэж болох юм. Тухайлбал, *нэгдүгээрт*, орчлон ертөнцийн үүсэл, тогтнолын өгүүлэмж бүхий агуулга байна. *Хоёрдугаарт*, сав, шим ертөнцийн талаарх агуулга нь хүний дотоод ертөнц, ёс суртахуун руу шилжиж хандсан тухай өгүүлэмж санаа байна. Энэ хэсэгт сайхи домог нь залуу нас, халуун цус, харааны цэц, эр чадал, эрхийн эрчиндээ бардамнасан харваачийн тухай мэт уншигдана. Ийм өгүүлэмж домгийн цагийн хожуу үед хамаарах нь дамжиггүй. Домгийн хоёр өгүүлэмж хоорондоо учир шалтгааны холбоотой.

Эдгээр агуулга илбэ дом, домгийн цаг үеэс эх аван, өргөн уудам нутгийн овог угсаатнуудыг хамарч, олон соёлын халаа сэлгээнд өртөж, утга нь өргөжин бүрэлдэж, задарч бутарч, өнөөгийн олон хувилбар бүхий байр сууриа олон тунаж тогтсон нь мэдээж хэрэг. Үүний нотолгоо хэмээвээс, *нэг талаас*, эрт галавын долоон нарт сэтгэлэгийн үе нь домгийн үүдэл өгүүлэмж байснаа харвах намнах

үйлийн эталон жишгийг ид хав болгон эрхэмлэсэн гавшгай шаламгай анчин гөрөөчний аж соёл, *нөгөө талаас*, унаа морио гарамгай эзэмших, сурамгай эдлэх малчин соёл зэрэг эрин цаг энэ домогт зуузай харшуулан шингэсэн явдал юм.

Аливаа домгийн нэгэн адил Эрхий мэргэний домог ч ил харагдах ба үл харагдах бүрдэлтэй. Домгийг ойлгоно гэдэг чухам тэрхүү ил бүрдэлд дөрөөлөн үл харагдах дайд руу нь нэвтрэн тайлал хийж, тэр цагийн хүмүүсийн төсөөллийн ертөнцөөр аялах билээ. Ийн авч үзэхэд домгийн сэтгэлгээний цөм нь орчлон ертөнцийн үүсэл гарлын тухай байдаг учраас сайхи домгийн үеийн хүмүүс *ертөнцийн байгууламжийн зарчмыг хэрхэн төсөөлж байж вэ* гэдэг асуудал гарч ирнэ. Нэг ёсондоо “эхлэлийн эхлэл” (Элиаде, 2020)-ийн асуудалд хариулт өгнө гэсэн үг. Сав ертөнц, шим ертөнц, амьтад, хүмүүс анх хаанаас, юунаас, хэрхэн үүсэв гэсэн асуултын хариуг домгоос эрж хайх юм. Энэ зарчим бол ерөнхий санаа, ерөнхий төсөөлөл байх билээ. Ийм ерөнхийг нэгж тодорхой ажиглалт, эргэцүүлэлд тулгуурлан гаргалгаа болгодог (Ж.Отгонбаяр, 2024).

Эрхий мэргэн хэмээх домог түүхэн урт удаан хугацааг туулж ирсэн болохоор олон өгүүлэмж, өнгө солонгорсон олон үе давхраатай болсон нь ойлгомжтой билээ. Иймд энэ домогт “хөрс хуулалт” хийж, задлан шинжлэх хэрэгтэй байдаг. Юуны түрүүнд домгийн өгүүлэмжээс **ахуй цаг хугацааг** нь тодруулах оролдлого хийж үзье. Нэгэнт домог маань хүний түүхийн олон үеийг туулсан учир цаг хугацааны олон хувилбар байх нь мэдээж хэрэг ээ.

Нэг. “Зургаан сумаар зургаан нарыг устгаад долоо дахь нарыг харвахаар шагайж, **шившиж** байтал...” гэсэн өгүүлэмжийн шивших үйлийг домог зүйн сэтгэлгээнээс өмнөх үеийн **илбэ домын буюу ид шидийн аргадах сэтгэлгээний (магийн) үеэс** уламжилж ирсэн зан үйл хэмээн үзэхэд төвөггүй юм. Онго шүтлэг амьдралын даяар чиг баримжаа болж байсан тэр цагт эртний хүмүүс аливаа үйлээ бүтээхийн тулд, багаж зэвсгээ хүчтэй, эрчтэй, ончтой мэргэн байлгахын тулд, мөн өөрсдөө эр бяргтай, шийдмэг зоригтой, гавшгай шалмаг, овсгоо самбагаатай байхын тулд дом шившлэг, жатгыг заавал хэрэглэдэг жамтай. Эс тэгвэл үйл эс бүтнэ гэсэн язгуурын сэтгэл итгэл, төсөөлөл тэднийг өвч бүрэн эзэмдэж байдаг.

Хоёр. Долоон нартай тэмцэлдэж буй өгүүлэмж нь байгалийн эмх замхгүй, айхавтар догшин сүр хүчтэй тулгарч, “тэнгэртэй тэрсэлдэж, газартай гацалдаж” байсан цагийн улбаа мөр юм. Энэ нь хүний ой ухаан түүхэн утгаараа сэрэх төдий тэмдгэрч, хүн өөрөө сэтгэлийн хоёрдмол байдлын (хуваагдлын) шаналгаанд унаж, дотооддоо тарчилж байсан *даяар хорио цээрийн эриний* үлдэц юм. Энэ үед тэнгэр шүтлэг бүрэн утгаараа ор сураггүй байсан ч, нар шүтлэг байсан цаг. Тийм ч учраас нэг нар үлдээж байгаа сэдэлтэй. Эртний овог хүмүүс өвөг дээдсийнхээ сүнсэнд хандан тайлга, тахил үйлдэн тэргүүн зэрэгт аргадан гуйх зүйл нь нар хур, үржил шим, үр төл байсан билээ.

Гурав. “Тэгтэл тэр нутагт ... харснаа харвадаг, харваснаа онодог хавтай мэргэн харваач байж гэнээ”. Эндээс ажихад, эрхийдээ эрчимтэй харваач намнаачийг эрхэмлэдэг цаг үе байжээ. Харвах намнах хэрэгсэл хөгжсөн, анчин гөрөөчин эрсийн эр бяр түүхэн утгаараа тэгширч, ан гөрөөний соёл биежин уламжилж, аж төрөх хэв маяг болсон үе байх нь ээ. Тогтвортой хөгжлийн уриа дивизтэй өнөө үед тохиромж муухан ч “Буга намнадаг нь манайд байна, булга эгнэдэг нь танайд байна” гэх хэлц тэр цагаас эхтэй байх аа.

Дөрөв. “... Адуу мал харангадаад...” гэснийг бодоход **таван хошуу мал хэдийнээ гаршиж, гэршсэн үе юм.** Адуу хожуухан гаршиж гэршсэн гэдэг. Зарим судлаач арван мянган жилийн өмнөөс огноолдог ч, дийлэнх олонхийн үзэх нь одоогоос зургаан мянга орчим жилийн өмнөөс эрчимтэй гаршуулж эхэлсэн бөгөөд дөрвөн мянга таван зуун жилийн өмнө гэхэд гэршсэн адууны үүлдэртэй

болсон гээд нутаг орноор нь зүүн европ, евразийн их талыг онцлох ажээ. Монголчуудын хувьд адууг гурван мянга таван зуун жилийн өмнөөс гаршуулж, гэршүүлсэн хэмээн судлаачид зонхилон үзэх ажээ.

Тав. “Хараацай шувууг садаа боллоо гэж харцага алаг мориороо хөөж...” Эндээс харахад, **мориор ан гөрөө хийдэг болсон цаг үе аж.** Эр хүн эзэн нь болж, эр морь унаа нь болж ижилсэн ханьсаж, **энэ хоёрын хүчийг нэгтгэн ашиглах болсноор** цаг хугацаа хэмжигдэж байна. Цуутын цагаагч гүү хэмээх үлгэрийн төгсгөлд ч Эрхий мэргэн хүү “уулыг тал, талыг там болтол бухсан” цолмон цоохор морины эзэн нь, морь хүлэг нь болон бие биеэ олж амар сайхан жаргадаг. Энэ нь үлгэр домог дахь биелэл боловч хэт ирээдүйдээ захиаслан сургаал номлол болгосон “мал бүхий угсаатны бодлого” юм хэмээн үзэхэд болохгүй нь юу билээ? Ер нь, Адуу эзэмшинэ гэдэг нэр төрийн хэрэг төдийгүй, эрх мэдлийн давуу байдал болжээ. “Адууныхаа хирээр исгэрнэ” гэх хэлц энэ цаг үеэс үүдэл сэдэлтэй болов уу.

Зургаа. “Эрхий мэргэн уурлаад харцага алаг мориныхоо урд хоёр хөлийг огтлоод хөдөө газар хаячихсан...” гэснээс үзэхэд **адуу, морь нь шүтлэг, шүтээн болоогүй байсан цаг** ажээ.

Долоо. “...Олон нарыг чи онож харваад устгаад өгөөч гэж **олон амьтан** түүнд очиж гуйж гэнэ” гэсэн өгүүлэмжээс харахад **энэ үед төрт ёс үүсээгүй байсан бололтой.** Хэрэв төрт ёс тогносон байсан бол Хаантны зүгээс Эрхий мэргэнд үүрэг болгох байсан болов уу. Тийм эс учир улс амьтан харваач мэргэнд хандсан ажгуу.

Найм. “... Эмээлт морь байхаа болиод энхэл тунхал газар амьдрах болно хэмээн морь нь ам тангараг өгч гэнэ”. Эзэн хүн, эмээлт морь хоёр ийн хэлэлцэх нь туульд олонтаа гардаг өгүүлэмж юм. **Тууль бол домог зүйн сэтгэлгээний оргил үеийн бүтээл.** Монгол тууль хүрлийн үед ид хөгжсөн гэж үздэг (Дулам.С., 2024). “Хүн бие нь хүрлээр бүтсэн...” гэх мэт. Жишээлбэл, Жангар туулийн Араг Улаан Хонгор баатар хүлэг сайн морь Оцол хөх халзандаа дараах үгийг хэлж байдаг.

"Маргааш өглөө
Нар мандахын цагт
Тэнгэрийн Төгөө Бүст
Намайг хүргэ!
Хэрэв эс хүргэвэл
Дөш болсон зоогоор чинь
Хэнгэргийн шир хийлгүй,
Хүдэр найман хавиргаар чинь
Хэнгэргийн дохиур хийлгүй,
Дөрвөн хар туурайгаар чинь
Зулын цөгц хийлгүй байхгүй би" гэв.

Оцол хөх халзан морь нь тэр үгийг сонсоод,

"Маргааш өглөө нар
Нар мандах хүртэл
Миний нуруун дээр тогт
Сайраар шувтраад унавал
Эзэн минь билээ гэж
Эргэж буцаж авахгүй шүү би" гэв.

Гүйсэн нь ч мэдэгдэлгүй,
Ниссэн нь мэдэгдэлгүй
Явсан их хурданд
Эмээлийн ард суугаад,
Алтан жолоондоо
Арай гэж хүрч явна.
Маргааш өглөө нь
Нар мандахын үед
Бумбын цагаан өргөөний
Өмнө ирээд буув... (Жангараас)

Одоо Эрхий мэргэн домгийн **ахуй нутаг орны талаар** ажиглалт хийж үзэцгээе.

Нэг. Ган гачиг болсон гэхээр өнгөн хөрсний ус чийг ховор говь, тал хээрийн бүс байх хэмээн бодож болох ч, "... газрын хөрс улайдаад, ус мөрөн ширгээд, ургамал мод хатаад" гэснийг бодоход **домгийн ахуй нэлээд энтэй уудам нутгийг хамарч** байсан бололтой.

Хоёр. Хараацай шувууг **мориор хөөгөөд давхиад** байхыг бодоход тал нутаг юмуу, уул хад, асга бартаа багатай газар орон бололтой.

Энэ домгийн нутаг орныг тодотгох хамгийн сайн чиглүүлэгч нь энд яригдах **өгүүлэмжийн эзэд болсон амьтад** юм. Харин тэдгээр амьтад домгийн цагаас хойш хэрхэн нүүдэл хийж, нутаг сэлгэн суурьшсан тухай миний мэдэх нь бага билээ.

Гурав. Хараацай шувууны тухайд мэргэжлийн ном зохиолд ийн өгүүлжээ. "Хараацай нь бор шувууны бүлгийн нэгэн овгийн шувуу бөгөөд энэ овогт нийт 19 төрлийн 83 зүйл шувуу багтдаг. Хараацай Антарктид, Авсралиас бусад бүх тив, эх газарт өргөн тархжээ. Африк тивээс гаралтай гэгддэг ба одоо ч Африкт хамгийн олон янзын хараацай амьдардаг болно. Цөөн хэдэн зүйл хараацай хүний үйл ажиллагаанаас болж устсан ч зарим зүйл нь хүний өөрчилсөн орчинд дасан зохицож, хүнтэй ойр амьдардаг.

Дундажаар 30-40 км/ц хурдтай нисэх ба 50-65 км/ц хурдалж чаддаг. Хараацай нь шавж, үр жимсээр хооллох ба нисэж байхдаа агнадаг. **Зөгий болон хэдгэнэ** авлахаасаа зайлсхийдэг аж". Хөөрхий тэр амьтан хүмүүнд авчирч өгөхөөр мөнхийн рашаан үмхэж явахад хорлогчин хэдгэнэ хатгаснаас тагт ургадаг арц, тайгад ургадаг хуш, талд ургадаг зээргэнэ дээррашаан дусч мөнх ногоон болсон гэдэг.

Монголчуудад, ерөөсөө дэлхийн домог зүйд хараацайн тухай үлгэр, домог, бэлгэдэл тун элбэг байдаг. Их төлөв эерэг дүрийн утгатай. Энэ домогт ч гэсэн Замбативийн Эрчимийн цор ганц эх сурвалж Нарыг **аварч үлдсэн** баатар болж байгаа сэдэлтэй ажээ.

Дөрөв. Тарваганы тухайд. "Тарвага (*Marmota*)-ны төрөлд нийт 14 зүйлийн тарвага багтдагаас монгол буюу сибирийн гэх тарвага нь Өвөр байгалийн тал, Тува, Монгол, Зүүн хойд Хятадын нутагт тархацтай. Эдгээрээс Монгол Улсад алтайн тарвага (*Marmota baibacina*) буюу хар тарвага, хээрийн тарвага (*Marmota sibirica*) буюу шар тарвага гэсэн хоёр зүйлийн тарвага байдаг.

Ази тивд ойролцоогоор 25 сая жилийн өмнө өнөөгийн тарваганы өвөг амьдарч байсныг гэрчлэх палеонтологийн олдворууд бий. Монгол орны хувьд Улз голын баруун эрэгт 5-6 мянга, Дундад халхын өндөрдлөг, Дарьганга орчимд 7-8 мянган жилийн өмнө тарвагатай байсныг тогтоосон. Монгол тарвага манай орны уулын хээрт зонхилж, хойт талын хөвч тайга ба урд талын говь цөлийн бүс хоорондын уудам зурвас нутагт далайн түвшнээс дээш 800-3800 м өндөрт тохиолдоно" хэмээн нэвтэрхий тольд дурджээ. Тарваганы тухай сэдэл өгүүлэмж монгол аман зохиолд элбэг.

Тав. Алаг даага буюу алаг даахайны тухайд.

“Ховордсон амьтдын тоонд бичигдсэн алаг даага буюу алаг даахай Монгол, Хятад, Казахстан, Киргизстан зэрэг Азийн цөөн оронд бий. Мөн Африк тивийн хойд хэсэгт тэдний төрөл төрөгсөд цөөнгүй. Дэлхий дээр алаг дааганы 33 зүйл байдаг бөгөөд үүнээс 20 гаруй нь Монгол оронд амьдардаг.

Гадны судлаачид алаг дааганы эрэлд гарахдаа Монголын говийг зүглэдэг нь тохиолдлынх биш. Элсний тажигдаахай, говийн алаг даахай, соотон алагдаахай, монголжин даахай, зүүнгар даахай зэрэг зүйл нь зөвхөн Монгол болон Өвөр Монголын нутагт тааралддаг байна” гэжээ. Зарим угсаатны заншил ёсонд алаг даагатай холбоотой зан үйл байдаг.

Ийнхүү эдгээр амьтад Их талын нэгэн хэсгээр нутагшилтай болохоор Эрхий мэргэний домог ч энэ л нутгийн нэгэн хэсэгт тэрлэсэн нь ойлгомжтой.

Сав, шим ертөнцийн үүсэл гарлын талаарх энэ домгийн өгүүлэмж нь өдөр шөнө ээлжилдэг болсон, хараацай шувууны сүүл салаа болсон, алаг даахай үүссэн, тарвага үүссэн, тарвага өглөө оройн гараатай болсон, тэрээр дөрвөн сарвуутай болсон, Эрхий мэргэн хуруугаа огтолож хоёр сугандаа хавчуулснаар тарваганы “хүн мах” үүссэн гэх зэрэг юм. Энд яригдаж буй өгүүлэмжүүдийг одоо цагийн сэтгэлгээний үүднээс авч үзэхэд хоорондоо даанч холбогдолгүй мэт авч домог зүйн сэтгэлгээний үргэлж зураглал, тэнд ертөнцийн тухай бүх тайлбар-домог нэгдмэл байдгийг харгалзвас уялдаа холбоог нь ойлгоход төвөггүй билээ.

Хүүрнэсэн энэ бүхнээ дэвсгэрлэн дараачийн бүлэг санаа руу шилжиж үзье. Харвах намнах хэрэгсэл, хөвчит нум бүтээсэн нь домгийн тэр цагийн өвөг дээдсийн хувьд бахдам амжилт, гүн их итгэл найдвар болж, асар хөөрөл баяслыг авчирч, эрхийдээ эрчтэй ид хавт харваачдад *Мэргэн* хэмээх цол, өргөмжит нэр соёрхон эрхэмлэж, мөнөөх зэвсгийнхээ шидэт хүч чадлыг хэтрүүлэн үнэлж, ямар ч анг агнаж, дайсныг дарна, тэр ч байтугай, алсын од мичдийг ч тэнгэрээс харван буулгана гэж төсөөлсөн бололтой байдаг. Ийм сэдэл Эрхий мэргэний өөр нэгэн хувилбар домогт бий юм. Энэ цагаас цэц мэргэн харваач нь даяар олноо эрхэм хүмүүн болж, бодит амьдрал нь болсон үлгэр, домогт “*Эрхий Мэргэн*” хэмээх өргөмж нэрээр алдаршсан ажгуу.

Анч, малч соёлыг нэгтгэн хослуулах, Мэргэн харваачдыг эрхэмлэн дээдлэх, үлгэр жишиг болгон даган дуурайж, даяар олны үйл хэрэг, нэр төр болгож, улмаар, эр хүний ид хав, овсгоо самбагаа, эмээлт морины бяраа чадал, нум сумны онч цэцийн хүчийг нэгтгэх, ёс суртахуун, андгай тангаргийг чанд мөрдөхийг сайхи домог сурталдсан нь хүмүүний амьдралын оршихуйн бодлого зорилгын шинжтэй номлол бүлгээ.

Харин дээр асуулт болгон тавьсан ертөнцийн байгууламжийн зарчмын тухайд гэвэл, энэ домогт өгүүлснээс үзэхэд, монголчууд **ертөнцийг дээд төрлөөсөө доод төрөл нь үүсэл гаралтай**, тухайлбал, хүн ам тангаргаа эс биелүүлбээс овог төрлөөсөө хасагдан төрөл доошилж адгуус болдог, эр морь доройтвоос харж хандах эзэнгүй харанхуй шөнийн амьдралтай мэрэгч болдог хэмээн нэгэн цагт төсөөлж байжээ. Ийн доошилж доройтох шалтгаан нь домгийн дээр дурдсан хоёр дахь өгүүлэмж буюу ёс суртахууны сэдэлтэй холбоотой аж. Ер нь ураг овгоос хасагдана гэдэг онго шүтлэгийн үеэс эхтэй, овгийн ёс дэг, хорио цээр зөрчсөнөөс үүдэн (хэрэв ийн зөрчигч айж ичиж, өөрийгөө бус эс болговоос) оногддог түгээмэл шинжтэй хатуу, дээд шийтгэл байж ирсэн аж. Нууц товчоонд ч энэ маягийн өгүүлэмж санаа буй.

Тийнхүү монголчуудын үлгэр, домог, суртал номлолд Мэргэн хэмээх өргөмж нэр мөнхөрч үлдсэн байх жишээтэй.

1. Эрхий мэргэн,
2. Хөхдэй мэргэн,
3. Тоодой мэргэн,

4. Алхай мэргэн,
5. Хан Сэгсэй Мэргэн
6. Арван Севүү Мэргэн хүү
7. Арван Гурван Настай Арлаа Мэргэн
8. Ар халхын арван гурван настай Арал Мэргэн
9. Атгаады /Атгааль/ Мэргэн
10. Мянган хувилгаант эрдэнийн шархал морьтой Эгэл Мэргэн
11. Найман настай Нанжин Мэргэн Баатар
12. Нэгэн Зуун Тавин Насыг Насалсан Хөгшин Луу Мэргэн Хаан
13. Хөөрхий Төрсөн Хүрэл Мэргэн Хаан
14. Хөх Халзан Морьтой Хөхөлдэй Мэргэн Хаан
15. Цагаадай Хааны Хэрээдэй Мэргэн
16. Ширээт Мэргэн Хаан
17. Шонхоодой Мэргэн Хөвгүүн
18. Эрийн Сайн Отноо Мэргэн
19. Эрийн Сайн Эгээдэй Мэргэн
20. Эрт Төрсөн Эрэл Мэргэн
21. Эрхийдээ Эрчтэй Эрийн Сайн Хамбуудай Мэргэн Хаан гэх мэт өдий төдий "Мэргэн" баатар, хаадын нэр алдар мөнхөрч үлджээ.

Манай ахмад үеийн эрдэмтдээс Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном (1988) нар "Эрхий мэргэн" хэмээх домог үлгэрийг тусгайлан судалсныг тэмдэглэсэн байдаг. Эрхий мэргэн домог үлгэрийн өнөө цагт тэргүүн яригддаг хувилбарыг анхлан сийрүүлж, уншигчдын хүртээл болгосон судлаачдын нэг нь эрдэмтэн Ш.Гаадамба ажээ (Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо, 2024). Тэрбээр судлаач багш Ж.Надмидын нэгэн бүтээлд хэвлэгдсэн (1957) "Эрхий мэргэн хүү" хэмээх бэсрэг туулийг онцлон судалж, жирийн анчин амьдралтай сайхи баатар шулам эмийг дарж, түүнээс гарсан Хүрэл хүүтэй тулалдсан тухай сэдэл өгүүлэмж зэргийг түшин Эрхий мэргэний домог үлгэрийг хүрлийн үетэй холбон тайлбарласан нь туулийн цаг үеийн хувьд ханатай санагдана. Тэр тууль нь:

Эртийн эрт цагт

Эрин цагийн түрүүнд

Эрдэнэ шаргал морьтой

Эрхий мэргэн хүү гэж байжээ хэмээн эхэлдэг аж.

Өнөө цагт аман зохиол судлаач, эрдэмтэн Р.Чүлтэмсүрэн "Эрхий мэргэн" домгийн барга, халх арваад хувилбарыг аман зохиолын түүх, хэл уран зохиолын үзэгдэл болох талаас нь харьцуулж авч үзжээ (Чүлтэмсүрэн.Р., 2021). Оросын монголч эрдэмтэн Г.Н.Потанин (1835-1920) Эрхий мэргэний домог үлгэрийг Сан бэйсийн хүрээ хавийн нутаг газраас халх хүнээс сонсч "Баруун хойд Монголын тэмдэглэл" (1919) бүтээлдээ хэвлүүлсэн гэх мэдээ байдаг. Харин ойрмогхон оросын монголч эрдэмтэн Сергей Юрьевич Неклюдов (2019) барга, хамниган, халх, дарьганга, буриад, урианхай, мянгад, захчин, дархад, үзэмчин, алтайчууд, тува, казак, башкир, чуваш гээд нутгийн мэдээлэгч нарыг оролцуулан жаран гаран хувилбарыг жишиж харьцуулжээ. Мөн түүнчлэн Эрхий мэргэний домгийн тухай Өвөр Монголын эрдэмтэн Хүрэлшаагийн сонирхолтой судалгаа байдаг (2016). Эдгээр судалгаа, мөн дээр ярьсан бүхнээс үзэхэд "Мэргэн" хэмээх тодотгол, өргөмж нэр нь эрт үеэс цэц мэргэн харваачийн алдар хүндийн бэлгэдэл болон домогт мөнхөрч, хойшид ч уламжлагдан өвлөгджээ.

Хойшид өвлөгдсөн жишээ хэмээвээс, Монголын нууц товчооноо Чингис хааны дээд өвөгт Хоричар-Мэргэн, Боржигидай-Мэргэн, Дорголжин Баяны хоёр хөвүүн Дува-Сохор, Добу-Мэргэн, Хорилардай-Мэргэн, Баргудай-Мэргэн ... Есүнгэ Мэргэн гэх мэтээр сайхи алдар уламжлагджээ.

Би энд Добу Мэргэн хэмээх алдрыг онцолж байна. Анчин гөрөөчин амьдралын хэв маягтай энэ эрхмийн нэрийн утгыг судлаачид ялгаатай тайлбарласнаар бичих хэлбэршил нь Добун мэргэн, Довон-Мэргэн хэмээн ялгаатай байна. Энэ цагт Добун мэргэн хэмээх нь судалгааны хэрэглээ илүүтэй байна. Энэ нэр оноосон нэр мөн үү гэдэг нь ярианы сэдэв болдог. Ер нь Монголын нууц товчооноо дурдсан Чингис хааны өвөг дээдсийг шууд махчилан ойлгож, тэднийг бодит хүн мэтээр үзэж, физик орон зай, цаг хугацаа оноох нь тэр бүр оновчтой бус. Тухайлбал, Бөртэ чоно нь бодит хүний оноосон нэр байхаасаа домог зүйн утгатай нэр байж мэдэх юм. Энэ тухайд зарим судлаач цохолбор хийн тэмдэглэсэн нь бий. Ингэхдээ тэд тэнгэр шүтлэгт ард түмнүүд их төлөв ой мод, эсвэл, жигүүртэн шувууны сүлд тотемтой байсныг эш үндэс болгодог. Тэгж үзвэл, бөртэ чоно хэмээх нэр нэн эртний онго шүтлэгийн үеийн хорио цээрийн тогтолцооны цээр нэрийн эерсэн утга байж болох юм.

Харин Добун мэргэн хэмээх нэрийн тухайд Нууц товчоон судлаач профессор Ж.Лувсандорж Добун-Мэргэн гэх учиртай гээд Дува хэмээх нэрийн тухай ч саналаа илэрхийлжээ. Жишээ нь, “Дува үгийн утга бүрхэг боловч монгол угсаатны хаад, домогт эрсийн нэрийн уламжлалд Дува, Дуба, Добу, Добун, Довон, Туваа, Тоба гэх олон хувилбар нэрс байдаг нь монголын эртний Тоба улсын нэрийн дурсгал бололтой” гэжээ (Лувсандорж Ж., 2019). Тэрбээр ийн үзэхдээ Добун буюу Довон гэдэг нь нэр (үгийн утга нь, товойсон, товгор, цул сүрлэг), харин Мэргэн гэдэг нь алдар хүнд гэхийн сацуу Добун гэсэн нэр “Довон хар бодон” хэмээх урианхай туульст гардаг нэр мөн бололтой гэжээ. Ингэж үзвэл Добун Мэргэн хэмээх нэр нь оноосон нэр биш, өргөмжит нэр, цол нэр ажээ. Чингис хаан хэмээх ч мөн л өргөмжит хүндэтгэл нэр билээ.

Нэрийн хорио цээр, хүндлэл эрхэмлэлийн гүн ёстой монгол угсаатны хувьд ийм байх нь жам. Нөгөөтэйгүүр, ер нь үгийн хорио цээр бол хүн төрөлхтний уугуул ёс, жинхэнэ нэр бол хүний биеийн амин хэсэг бөгөөд сүнсний орон тул хөндлөнгийн элдэв дайрлагаас онц нууцалж, төлөөний нэр хэрэглэх нь түгээмэл үзэгдэл байж ирсэн түүхтэй.

Нууц товчоонд өгүүлснээр (Лувсандорж Ж., 2019), Добун Мэргэн нь Бурхан Халдунд үе улиран аж төрдөг анчин гөрөөчин удамтай. Түнхэлиг горхин руу нүүж ирсэн Хорь түмэдийн Хорилардай Мэргэнийхэн ч анчид гөрөөчид.

Тэдний залгамж болох Бодончар Мунхаг басхүү гөрөөчин, шонхорчин эрдэмтэй. Харин Бодончар шувуулах завсартаа очиж эсэг цэгээ уудаг, Түнхэлиг горхин руу нүүн ирсэн тэд бүл хүмүүс бол **мал аж ахуйтан** ажээ. Энэ бүл иргэнийг Бодончар ах нарын хамт дагуулах болсон нь ан гөрөө, мал ахуй хослон хүчирхэгжсэн байдаг. Энэ нь чухамдаа Эрхий Мэргэний домгийн номлол ёсоор нэгэн биед хоёр эрдэм чадал дахин үргэлжлэн хослон цогцолсон өгүүлэмж билээ.

Эр хүний бял чадлыг эрхий хурууны хүч тамир, онч эрчмээр илтгэсэн сэдэл өгүүлэмж Монголын нууц товчоонд ч байдаг. Тухайлбал, 139 дүгээр зүйлд жүрхин иргэний тухайд “элгэндээ сөст эрхийдээ ончтан” гэсэн байдаг бол 254 дүгээр зүйлд Цагаадайн үгийг сөрөн хандахдаа Жөчи ийн хэлдэг, “Онтдож (хол харваж) чамд гартваас эрхийгээ огтолж огоорсугай! Абалдан (барилдаж) чамд ялагдваас унасан газраас бүү боссугай!”. Эрхий Мэргэний домгийн өгүүлэмж-андгай хожмын төр улсад ийнхүү тангаргийн жишиг ёс болон хэвшсэн бүлгээ.

Жич өгүүлэхэд, “сайн эрийн ганзаганы хүнс” болно гэсэн тангарагтай тарвага хэмээх нь басхүү монголчуудын жиших сэтгэлгээнд априори өгөгдөл болж тогтсон бололтой байдаг. Жишээлбэл, Монголын нууц товчооны 90 дүгээр зүйлд “Бэлгүдэй оготор дарги хонгорыг унаж, тарвагачлахаар явсан бүлгээ. Үдэш нар шингэсний хойно Бэлгүдэй оготор дарги хонгорт тарвага нугсалзтал ачиж,

явган хөтөлж ирэв” хэмээн өгүүлсэн бол 199 зүйлд Чингис хаан Тогтоагийн хөвгүүдийн араас Сүбэгээдэйг нэхүүлээр илгээхдээ тэднийг жигүүрт болж тэнгэрт гарвал шонхор болж нисч барь, загас болж тэнгис далайд орвоос тор болж шүүж барь, *тарвага болж газарт орвоос* царил болж ухан төнхөж гүйц хэмээн зарлиг болгодог билээ.

ДҮГНЭЛТ

Эрхий Мэргэний домог үлгэрт тунхагласан эр хүн, хүлэг морины хүчийг нэгэн цул болгох гэсэн цуутай суртал номлол хожим Монгол төрийн Тэнгэр үзэлд уусан тэрлэсэн нь мэдээж хэрэг. Тэнгэр үзлийг зарлигаа болгосон Монгол Гүрэн дэлхий ертөнцийг илбэн тохинуулж, Даяар амгалан (Рах Mongolica)-г бүтээх цэрэг дайны хүчирхэг гүрэн болоход цэц мэргэнчүүдийн үүрэг онцгой байсныг өгүүлэх юун. Энэ гүрэн улс бүхэлдээ мэргэн харваачдын морьт арми байлаа!

Харааны цэц ончийг илэрхийлж асан “Мэргэн” хэмээх алдар хүнд хожимдоо онохуй, оногдохууны харилцааг илтгэн билгийн мэлмий, сэцэн оюун, мэргэн ухааны шинжээ (Дэй сэцэн, Чандага цэцэн, их сударч Мэргэн Гэгээн, Саган Цэцэн гэх мэт) болон зэрэгцэх утгыг олсон билээ. Нэгэн цагт монгол домог зүйн чин хүслэн, номлолынх нь хураангуй товчоо-нэр болж асан Эрхий Мэргэн хэмээх өргөмжит нэрийн хожмын нэгэн төлөөлөл бэлгэдэл нь Добу Мэргэн алдартад оногдон тохиосон ажгуу.

Prestigious names in Mongolian mythology: Erkhii mergen and Dobu mergen

Khulud Jamyant Otgonbayar 

Master, Lecturer of the Department of Social Science, School of Humanities and Social Sciences,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

This article aims to clarify the internal ideological connection between the Mongolian Secret History narrative and mythological thinking of the Mongols through a mythological story. With the aim of doing so, we emphasize the agricultural culture of the ancient Mongols and argue that some of the names in the lineage of Chinggis Khaan ancestors are not given names, but carry mythological meanings. The ancient Mongols combined the hunting and agricultural husbandry. The Golden Clan of Chinggis khaan were hunters. The Great State they established was a military empire.

Keywords: *Mythological thinking, myths, ideology, prestigious names, and theism*

Ном зүй

Гаадамба Ш. (1988). "Домог үлгэрийн сэтгэлгээний асуудалд". С. Х. Гаадамба Ш.-Д, *Монгол ардын аман зохиол*. <https://www.scribd.com/document/705438755/DOMOG-ULGERIIN-SETGELGEENII-ASU-Sh-Gaadamba-ээс> Гаргасан

Дулам.С. (2024). *Мифы монгольского народа*. Москва: Эскмо.

Дэлгэрэнгүй тайлбар хийсэн: Г.Алтансүх, Ж.Базарсүрэн, Г.Билгүүдэй, Л.Ганбат, Ц.Гүнчин-Иш, Ж.Гэрэлбадрах, С.Дулам, М.Жавхлан, Э.Жаргалмаа, Б.Золжаргал, Л.Маналжав,

- С.Мөнхсайхан, Э.Мөнх-Учрал, А.Пунсаг,. (2024). *Дэлгэрэнгүй тайлбартай Монголын нууц товчоо*. Улаанбаатар: Анд хэвлэлийн газар.
- Отгонбаяр Ж. (2024). *Домог зүйн философи судалгаа*. Улаанбаатар.
- Лувсандорж.Ж. (2019). *Монголын нууц товчоон (Их Монгол Улсын нууц түүх)* (Б. Нэмж зассан II хэвлэл). (х. б. Одоогийн монгол хэлний орчуулга, Хян.) Улаанбаатар.
- Надмид, Ж. (1957). *Монгол ардын үлгэр*.
- Неклюдов.С.Ю. (2019). *Фольклорный ландшафт Монголии. Мифы и обряд*. . Москва: Индрик.
- Потанин.Г.Н. (1919). *Монголын баруун хойд нутаг* (Б. IV).
- Хүрэлшаа. (2016). *Монгол домгийн соёл судлал*. Улаанбаатар.
- Чүлтэмсүрэн.Р. (2021). *Монгол аман зохиолын түүх*. . Улаанбаатар.
- Элиаде, М. (2020). *Домог зүйн сэтгэлгээ*. Улаанбаатар.